



**ХЭНТИЙ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 06 сарын 27 өдөр

Дугаар 4/30

Мөрөн сум

**“ЦЭЦЭРЛЭГИЙН ТОГЛООМЫН ТАЛБАЙ,
ДОТООД ЗАСВАР”-ЫН АЖЛЫН ЯВЦАД ХЯНАЛТ
ТАВИХ, ХҮЛЭЭН АВАХ КОМИСС БАЙГУУЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Сумын Засаг даргын 2025 оны 03 сарын 27-ний өдрийн А/52 тоот захирамраар байгуулагдсан Сумын үнэлгээний хорооны 2025 оны 05 сарын 02-ний өдрийн 07 тоот зөвлөмжийг тус тус үндэслэн ТУШААХ нь.

1. “АРХАЛДАЙ” ХХК нь сумын ОНХСангийн хөрөнгө оруулалтаар “Цэцэрлэгийн тоглоомын талбай, дотоод засвар”-ын ажлын тендерт ялж 2025 оны 06 сарын 01 аас 2025 оны 08 сарын 01 -ний дотор хийж гүйцэтгэх гэрээ байгуулсан тул уг ажлын явцад хяналт тавих, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, хүлээн авах эрх бүхий сумын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай

Коимссын дарга: Д.Пүрэвжаргал Цэцэрлэгийн эрхлэгч

Гишүүдэд: Ө.Өнөрөө Нийгмийн ажилтан

Э.Балчиндорж Цагаан толгой багийн Засаг дарга

Ш.Баасандорж Байгаль орчны хяналтын улсын байцаагч

Д.Дашдорж Цэцэрлэгийн нярав

2. “АРХАЛДАЙ” ХХК -аас хүлээн авах “Цэцэрлэгийн тоглоомын талбай, дотоод засвар”-ын ажлыг гэрээний хавсралт болох техникийн тодорхойлолтийг үндэслэн өнгө үзэмж, чанар байдлыг нэг бүрчлэн шалгаж, фото зургаар баримтжуулан акт үйлдэж хүлээн авахыг комиссын дарга (Д.Пүрэвжаргал) -д үүрэг болгосугай.

3. Засварын үйл ажиллагаанд захиалагчийн зүгээс хөндлөнгийн хяналт хийхдээ Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлд заасан Захиалагчийн чиг үүргийг хэрэгжүүлж, үйл ажиллагааныхаа чиглэлээр Аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газартай нягт хамтарч ажиллахыг комиссын нийт гишүүдэд даалгасугай.

ДАРГА

Н.НАМЖИЛНОРОВ